



БАЯНХОНГОР АЙМАГ
БАЯН-ОВОО СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 02 сарын 13 өдөр

Дугаар А/16

Хөхбүрд

Хүүхэд үрчлүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Иргэний Улсын бүртгэлийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.4, 11.5, 11.6, Гэр бүлийн тухай хуулийн 55 дугаар зүйлийн 55.7 заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Тус сумын Асгамба 3 дугаар багийн харъяат Б.Лхагвасүрэн, эхнэр С.Цэцэгээ нар нь том охин С.Цонцолмаагийн 2 дахь хүү болох Сугаррагчааг 9 сартайгаас нь өсгөсөн бөгөөд албан ёсоор үрчлэн, гэрчилгээг өөрийн овгоор гаргуулах хүсэлтийг хянаж үзээд дүгнэлтийг үндэслэн Б.Лхагвасүрэн эхнэр С.Цэцэгээ нарт үрчлүүлэхийг зөвшөөрсүгэй.

2.Сугаррагчаа хүүг эрүүл саруул өсч бойжих, сурч боловсрох орчин нөхцөлөөр хангаж эцэг эхийн хайраар халамжлан өсгөхийг Б.Лхагвасүрэн эхнэр С.Цэцэгээ нарт үүрэг болгосугай.

3.Сугаррагчаа хүүтэй холбоотой үрчлэлтийн бүртгэлийг хөтлөн иргэний бичиг баримтыг шинэчлэн олгохыг Улсын бүртгэгч (З.Ёндонжамц)-д үүрэг болгосугай.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж эцэг эхийн үүрэг оролцоог хангуулан ажиллахыг Нийгмийн бодлогын мэргэжилтэн (Ө.Ариунзаяа)-д даалгасугай.

ДАРГА Ж ХАТАНБААТАР



- 642201183